



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 5/22

Хэрлэн сум

Ж.Ганбаатарыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.20, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.5, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Жигжидийн Ганбаатар нь Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт шилжин ажиллах болсон тул 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөр тасалбар болгон ажлаас чөлөөлсүгэй.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга:

Б.Дарханбаатар Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Ш.Эрдэнэжаргал Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн


Э.Ариунтунгалаг Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

Д.Энхтуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын нярав

3.Ж.Ганбаатарын ажлыг зохих хууль, журмын дагуу хүлээлцүүлэхийг комиссын бүрэлдэхүүн (Б.Дарханбаатар)-д, холбогдох тооцоог хийж дуусгахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ